

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2020-08-31/**

Ажлын хэсгийн 51 дугаар хуралдаан 2020 оны 8 дугаар сарын 31-ны өдрийн 11.00 цагт цахим хэлбэрээр зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд УУХҮЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Эдийн засаг, хөрөнгө оруулалт, судалгааны хэлтсийн дарга Д.Дамба, ахлах шинжээч Ч.Цогтбаатар, Ашигт малтмал газрын тосны газрын мэргэжилтэн Г.Оюунтуяа, Авилгатай тэмцэх газрын ажилтан Д.Цэнд-Аюуш, Бадрах энерги ХХК-ийн олон нийтийн харилцааны асуудал эрхэлсэн захирал Ц.Энхжаргал, Бороо гоулд ХХК-ын татварын нягтлан бодогч Т.Мөнхзул, Эрдэнэс монгол ХХК-ийн хяналт, мониторингийн албаны дарга Н.Баттулга, Нүүрс ассоциацийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Оюутолгой ХХК-ийн менежер Б.Ренчинпагма, ахлах менежер Т.Мөнхбат, Петроматад ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч Б.Отгонбаяр, Рио Тинто Монгол ХХК-ын менежер н.Даваасүрэн, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ийн тэргүүн Д.Сүхбаатарыг орлож гүйцэтгэх захирал Б.Баяраа, Захиргааны шинэ санаачилга ТББ-ийн тэргүүн Д.Цэрэнпүрэв, болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов.

Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 17<sup>1</sup> байгууллагын төлөөлөл оролцож, ирц 51,5 хувьтай байв.

Мөн хуралдаанд УУХҮЯ/АХБ-ны ОҮЗС-ийн төслийн зохицуулагч З.Баярхүү, Мэдээлэл технологийн зөвлөх О.Мөнхбат, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

**Хуралдааныг УУХҮЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Эдийн засаг, хөрөнгө оруулалт, судалгааны хэлтсийн дарга Д.Дамба удирдан явуулав.**

Д.Дамба: Сайн байцгаана уу, Өнөөдөр бид ОҮИТБС-ын Ажлын хэсгийн 51 дүгээр хуралдааныг цахим хэлбэрээр хийж байна. Өнөөдрийн хуралдаанд хамгийн хол Япон улсаас манай төслийн зохицуулагч Баярхүү оролцож байгааг дуулгахад таатай байна. Өнгөрсөн хугацаанд Ковид-19 цар тахал гараад Улсын онцгой комиссоос олон нийтийн арга хэмжээг хориглосон байгаа. Энэ хугацаанд бид ажлын албатайгаа хамтран ажлаа цахим хэлбэрээр зохион байгуулж ирсэн гэдгийг дурдмаар байна. ОҮИТБС-ын 50 дугаар хурлаас хойш багагүй хугацаа өнгөрсөн байна. Өнөөдрийн хуралдаанаар ОҮИТБС-ын 2020 оны төлөвлөгөөний явцын талаарх танилцуулга болон ОҮИТБС-ын сургалтын модулийн танилцуулгыг сонсох байдлаар явагдана. Хурлын төгсгөлд өнөөдрийн арга хэмжээний талаарх хэлэлцэх асуудал болон хурлын дэгийн талаар хэлж болно. Өөр саналтай гишүүд байвал хэлж болно.

Д.Эрдэнэчимэг: Одоо байгаа ирцийг харахад хурлын ирц бүрдээгүй юм шиг харагдаад байна, одоо ирээгүй байгаа ч оролцох хүмүүс байгаа байх. ТАН эвслээс

<sup>1</sup> УУХҮЯ нь Ажлын хэсгийн ахлагч, мөн гишүүн гэдгээрээ 2 төлөөлөлтэй болсон байгаа.

хурлын хэлэлцэх асуудалд ОУИТБС-ын тайлан нэгтгэлийн ажлын явцын талаар мэдээлэл авах санал гаргасан байсан энэ талаар танилцуулах уу?

Д.Дамба: Хуралдаанд оруулах асуудлын талаар бид ярилцсан, нэгтгэл тайлангийн явцын талаар Цолмон даргын танилцуулгад багтаж байгаа, мэдээлэл хийгдэнэ. Энэ хуралдаанаар бид тодорхой шийдвэр гаргахгүй, ерөнхий мэдээлэл сонсох байдлаар явагдана, хурлын явцад гишүүд нэмэгдэх боломжтой. Хэрвээ хурлын ирц бүрдээгүй байна, хойшлуулна гэвэл саналаа хэлж болно.

Д.Эрдэнэчимэг: Өнөөдөр шийдвэр гаргахгүйгээр мэдээлэл сонсох байдлаар зохион байгуулж байгаа бол хурлаа хийсэн нь зөв гэж бодож байна, хүмүүс ч нэмэгдэх байх. Хурлын тэмдэглэлээ хөтлөөд ирээгүй гишүүддээ хүргүүлье.

З.Баярхүү: Хурлаа хийх саналтай байна.

Ш.Цолмон: Өнөөдрийн хуралдаанд 26 гишүүн оролцохоор бүртгүүлсэн, одоогийн байдлаар 12 гишүүн орсон байна. Зарим нь явцын дунд холбогдох байх, цахимаар болохоор гар утаснаасаа ч холбогдох боломжтой байгаа, бүх хүмүүст линк холбоосыг хүргүүлсэн байгаа. Хурлаас том шийдвэр гарахгүй, мэдээлэл хүргэж байгаа учраас чөлөөтэй байдлаар хийх боломжтой гэж харж байна. Хурлын яах хийх эсэх талаар гишүүд, удирдлагууд шийдвэр гаргах байхаа.

Гишүүд хурлын үргэлжлүүлэн танилцуулгаа сонсох нь зүйтэй гэж үзэв.

Д.Дамба: Өнөөдрийн хуралдааныг УУХҮЯ-ын Төрийн нарийн бичгийн дарга, ОУИТБС-ын нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал удирдан зохион байгуулах байсан ч тодорхой шалтгааны улмаас ирж амжсангүй иймээс миний бие удирдан явуулахаар боллоо. Ингээд хурлын хөтөлбөрийн дагуу ОУИТБС-ын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулна.

### **I. Танилцуулга: Монголын ОУИТБС-ын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц**

Ш.Цолмон: Сайн байцаана уу, Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2020 онд ОУИТБС-ыг Монгол Улсад Азийн Хөгжлийн банкны техник туслалцааны ТА - 9752 MON тоот төслийн дагуу хэрэгжүүлж байна. 2020 оны 1 сарын 1-нээс өнөөг хүртэл хийсэн ажлуудыг товч дурдвал:

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нарыг 2019 оны ОУИТБС-ын тайлангаа гаргахад утсан болон цахим холбоотой байж, арга зүйн зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлэв. Үүний үр дүнд 2101 компани 2019 оны тайлангаа гаргахад 1458 компани тайлангаа хуучин маягтаараа гаргасан байна.

ОУИТБС-ын тайлан гаргах үүрэг бүхий төрийн бүх шатны байгууллагуудтай холбогдож, мэдээлэл өгөх, арга зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа зохион байгуулсны үр дүнд 2423 компаниас орлого хүлээн авснаар 5 агентлаг, 19 аймаг, 6 дүүрэг тайлангаа гаргасан байна.

“Гэрээний ил тод байдлын” портал ажиллаж байна. Үүнд 797 гэрээг ил тод болгож, нийтлүүлсэн байна.

2019 оны нэгтгэл тайлан гаргах Хараат бус хянагч нэгтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо 5 хуралдаж, оролцогч нарын зүгээс гомдол гаргаснаар Сангийн яаман дээр хянах зэргээр хугацаа алдсан учир дахин зарлах болсон бөгөөд Үнэлгээний хороог өөрчлөн байгуулав. Тендерийг 8 дугаар сард дахин зарлаж, тендерээ 9 дугаар сард багтаан дуусгаж, гэрээгээ байгуулахаар ажиллаж байна.

УУХҮЯ дээр “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хууль” ийн төслийг шинэчилэн боловсруулах ажлын хэсгийг байгуулсан дагуу 3 удаа хуралдаж, хуулийн үзэл баримтлалыг УУХҮЯ, ХХДХЯ, СЯ-аар батлуулсан. Үзэл баримтлалын дагуу хуулийн төслийг дагалдах хуулиудын хамт шинэчилсэн. Журам ёсоор шинэ сайд нараар баталгаажуулах ажил хийгдэж байна.

Ажлын хэсгийн 50-р хуралдааныг 1 дүгээр сард зохион байгуулж, 2020 оны ажлын төлөвлөгөөний талаар хэлэлцүүлж батлуулсан байна. Үндэсний зөвлөлийн шийдвэрийн дагуу ОҮИТБС-ын шинэ стандартын дагуу компаниудын маягтуудыг шинэчлэн боловсруулж, 2-р сарын 21 нд Үндэсний статистикийн хороогоор зөвшөөрүүлж, улмаар Уул уурхай, хүнд сайдын 3 дугаар сарын 5-ны тушаалаар батлуулж, ХЗДХЯ дээр 4-р сарын 21-нд бүртгүүлж, Legalinfo.mn дээр хэвлэгдсэн. Шинэ маягыг 8-р сарын 17-ноор эцсийн байдлаар цахим сүлжээнд оруулж, тайлагнуулж эхлэсэн.

Ковид-19 цар тахлын улмаас олон нийтийг хамарсан сургалт, бага хурал зохион байгуулах ажлыг хязгаарласан учир 50 гаруй компаниудад тайлангийн шинэ маягыг танилцуулах 4 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Нийт 55 ажил төлөвлөснөөс 28 ажил хэрэгжих шатандаа, 25 нь хүлээлтийн байдалтай байна. Цаашид 2 ажлыг цуцлах, ирэх жилийн төлөвлөгөөнд оруулах саналтай. 25 хүлээгдэж байгаа ажлуудыг үлдсэн хугацаанд хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах шаардлагатай болно. Үлдсэн шахуу хугацаанд төлөвлөсөн бүх ажлуудаа хэрэгжүүлэх талаар талууд хамтран ажиллана гэдэгт итгэж байна. (танилцуулгыг хавсаргав)

Д.Дамба: За баярлалаа, ОҮИТБС-ын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний явцын талаарх танилцууллаа. 800 гаруй гэрээг ил тод болгосон, ОҮИТБС-ын тайлангийн шинэ маягыг батлуулж, танилцуулах цахим сургалтыг зохион байгуулсан гэх мэт ажлуудыг хийсэн байна. Танилцуулгатай холбоотой асуулт, санал байвал асууж болно.

Д.Эрдэнэчимэг: Цаг үеийн нөхцөл байдалтай уялдаад төлөвлөгөөнд заасан ажлуудаа цахимаар зохион байгуулж байгаад талархал илэрхийлье. Ажлын алба нь УУХҮЯ-нд шилжээд, санхүүжилт нь АХБ-наас гаргаж байгаа. Ажлын албаны

санхүүжилтийн дүн, гэрээний хугацаа хэдий хүртэл билээ, түүнээс цаашид ажлын албаны зардлыг санхүүжүүлэх талаар улсын төсөвт тусгаж чадсан уу?

Ш.Цолмон: Азийн хөгжлийн банкны санхүүжилт 2019 оны 8 сараас ирэх оны 10 сар хүртэл хэрэгжихээр байгаа, үүнээс ажлын албаны цалин болон бусад сургалтын зардлууд гарахаар байгаа. Төлөвлөгөөнд санхүүгийн эх үүсвэрийг тодорхой тавьсан байгаа, өнөөдрийн байдлаар хязгаарлалтай байгаа учраас тодорхой санхүүжилт аваагүй, зөвхөн цалингаа л авч байгаа. Хүлээгдэж байгаа 25 ажлыг яаран цуцлахыг бодохгүй байна, хэрвээ хорио цээр тавигдвал орон нутгийн сонгуулийн дараагаас орон нутагт зохион байгуулах сургалт, бүсийн семинарыг хийх боломжтой мөн хэлэлцүүлэгийг зохион байгуулах боломжтой гэж харж байгаа. АХБ-ны санхүүжилт 2021 оны 10-р сард дуусахаар байгаа цаашид яах эсэхийг одоогоор хэлэхэд эрт байна. Хэрвээ хуулийн төсөл батлагдсан тохиолдолд санхүүжилт шийдэгдэх байх гэсэн найдлага байгаа. Ямар ч байсан 2020 онд АХБ-наас 136 сая төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар төлөвлөсөн байгаа.

З.Баярхүү: Улсын төсвөөс авах санхүүжилт тодотголд батлагдсан дүнгээрээ орсон байгаа, одоогоор ямар нэг хасагдсан гэсэн мэдээлэл байхгүй учраас төсөвт тэр хэвээрээ байгаа гэж ойлгож байгаа. 2021 оны 10 сараас АХБ-ны санхүүжилт дуусна. НҮБ-ээс яаманд хэрэгжүүлэх төслийн санал авсан, бид саналаа боловсруулж өгсөн байгаа. Цаашид АХБ-д санхүүжилтийг үргэлжлүүлэх саналыг өгнө, УУХҮЯ-ны сайд ойрын хугацаанд АХБ-ны удирдлагуудтай уулзахаар төлөвлөж байгаа.

Т.Мөнхбат: Төлөвлөсөн ажлуудаас хийгдээгүй ажлууд ондоо багтан хийгдэж амжихаар байгаар юу? Амжихгүй бол яах вэ? Сүүлийн үед сонгуультай холбоотойгоор уул уурхайн салбарын нэр хүндэд муугаар нөлөөлөх хандлага байгаа. Олон нийтэд хандсан танилцуулга, ямар ажил хийх төлөвлөгөө байна вэ?

Ш.Цолмон: Үлдсэн хугацаанд ажиллах бүрэн боломж байгаа гэж үзэж байна. Эдгээр ажлыг хийж хэрэгжүүлэхэд хамтран ажилладаг байгууллагууд, гишүүд дэмжиж тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна. Баруун, төвийн бүсийн уулзалт, семинарыг зохион байгуулах, салбарын өгөөжийн танилцуулахад гишүүд, байгууллагууд хамтран ажиллах байх үүнийг хамтын хүчээр зохион байгуулах болно. Шинэ маягтын дагуу тайлан гаргахад ялангуяа компанийн хувь нэмэр ихээхэн хэрэгтэй гэж харж байгаа.

Т.Мөнхбат: Төвийн бүсийн сургалтаар тайлангийн талаарх мэдээлэл, салбарыг үр өгөөжийг сайн таниулахгүй бол бидний ажлын үр дүн сайн харагдахгүй болж байна.

Д.Эрдэнэчимэг: Санаачилгын хүрээнд хийж байгаа ажлыг олон нийтэд суртчилвал хуулийн төсөл батлагдахад нөлөөтэй байх. Одоогоор аудитын компани сонгоогүй байгаа юм чинь наана нь боломжтой мэдээллийг олон нийтэд ил тод мэдээллийн сүлжээнүүдийг ашиглан болгох хэрэгтэй байна. Өмнө хийсэн богино хугацааны шторкоо олон хийтэд хүргэж байвал зүгээр болов уу? Хүмүүс хараад цааш нь гүнзгийрүүлээд харах боломжтой линк, замыг зааж өгөх замаар мэдээллийг түгээх нь чухал байх. Орон нутагт зарим мэдээлэл богино хэмжээний шторкуудыг үнэ төлбөр хямдаар байршуулах боломж байдаг юм байна. Нөгөө талаар аймгууд болон сумдууд цахим групптэй болчихсон тэр дотор нутгийн иргэд их идэвхтэй байдаг юм байна, тийм группуудэд мэдээлэлээ тавих нь зүйтэй байна үүний тулд орон нутагтай холбогдох хэрэгтэй байх.

З.Баярхүү: Бид та бүхний саналыг дэмжиж байна, бид мэдээллийг яаж олон нийтэд түгээх талаар яг энэ асуудлаар хоорондоо ярилцаж байсан. Цаашид тодорхой саналуудыг боловсруулан ажиллах болно. Мэдээлэл технологийн зөвлөх Мөнхбаттай түлхүү хамтран ажиллахаар ярьсан байгаа.

Д.Дамба: За баярлалаа. ОУИТБС-ын үйл ажиллагаа болон салбарын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох ажилд УУХҮЯ, Ажлын алба болон бусад төрийн байгууллагууд хамтран ажиллаж байгаа. Өнгөрсөн Засгийн газрын дөрвөн жилд яамны зүгээс хийсэн ажлын хүрээнд тайлан гаргаж, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тайлагнасан байгаа.

Н.Баярсайхан: Цахим сургалтууд хийгдсэн байна, иймээс сургалтын төсөв хэмнэгдсэн байх гэж бодож байна. Ажлын төлөвлөгөөний 3,2 болон 7,4 т заасан ОТОАХ ийн мониторинг хийх ажлыг хасах санал гаргасан байна. Үүнийг хийх санал байна. ТАН эвслийн гишүүд санаачлаад, тухайлбал, гэрээ яагаад ид тод болохгүй байна, нээлттэй болгоход юу саад болж байна, ямар төрлийн гэрээ байна, нээлттэй болсон гэрээнүүдийг ашиглах боломж ямар байна г.м. талаар дүгнэлт зөвлөмж гаргах хэрэгтэй. Хэмнэгдсэн төсвөөр тодорхой ажлуудыг хийх саналтай байна. Өнгөрсөн жил орон нутгтаа ОУИТБС-ын ажлыг сайн хийсэн гэж нэг аймаг, нэг сумын дэд зөвлөлийг урамшуулж УУЯ ны жуух бичгээр шагнасан. Эдгээр дэд зөвлөлийн үйл ажиллагааг баримтжуулж видео кино хийж олон нийтэд түгээх боломж байна. Харин асуулт нь Уул уурхайн яамнаас УИХ-ын байнгын хороодод тайлан хүргүүлж мэдээлэл өгсөн гэж тусгасан байна ямар хүмүүст өгсөн бэ? Хэзээ ямар албан тоот явуулсан бэ?

Ш.Цолмон: Төлөвлөгөөнд байгаа 2 ажлыг энэ онд амжихгүй гээд цуцлах саналтай байгаа, бусад ажлыг хийж болох байх. Саналыг хүлээн авч байна, тодорхой санал боловсруулаад ирүүлж болно.

Н.Баярсайхан: 2020 оныг “Дэд зөвлөлийг чадавхижуулах” жил гэж зарласан байгаа. Иймд хэмнэгдсэн төсвөө энэ ажилд зориулах, манай ТАН эвслийн ажилтнуудтай хамтран ажиллах, тэдний мэдлэг туршлагад тулгуурлан, тэдгээрийн ажилладаг дэд зөвлөлүүдийг чадавхижуулах санал байна. Энэ оны төсөв мөнгө нь юу болж байна, танагдаж хасагдсан уу, санхүүжилт бүрэн орж ирсэн үү? Сонгууль болоод хүмүүс цуглуулж болж байна, одоо орон нутгийн сонгууль гээд хүмүүс цугларах л байх. Иймд орон нутагт чиглэсэн ажлыг хийж болох байх гэсэн саналтай байна.

Ш.Цолмон: Үлдсэн хугацаанд дээрх ажлуудыг хийж болно. 11,12 сард хийх байх, харин 9, 10 дугаар сард ОУИТБС-ын нэгтгэл тайлан гаргах компаниа сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, эхлэлийн семинар хийх зэрэг ажлуудыг зохион байгуулах болон нэгтгэл тайлангийн ажилдаа түлхүү анхаарч ажиллах бодолтой байна.

Н.Баярсайхан: Төрийн байгууллагын семинарыг яг бүсчлээд хийхээр байр багтаамжаас болоод дэд зөвлөлийн гишүүн ТББ, Иргэдийн төлөөлөл д оролцох боломжгүй болдог, зөвхөн дарга нар ирчихдэг сул талтайг анхаарах. 09 сарын 28 нд Орон нутгийн сонгуулийн сурталчилгаа эхлэнэ, соннгууль нь 10 сарын 15 нд болох тул 10 дугаар сарын сүүлээр хиймээр байна.

Ш.Цолмон: 9,10 дугаар сард аудитын компаниа сонгон шалгаруулна, гэрээ байгуулж, гол чиглэл өгөх ажлууддаа илүү анхаарч ажиллана. Орон нутгийн ажлыг орон нутгийн сонгуулийн дараа л хийх боломжтой болох байх.

Д.Эрдэнэчимэг: Бид төлөвлөгөөнд байгаа зардал нь хэмнэгдсэн ажлуудыг хараад энэ төсөв дээр нь ТАН эвслээс хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан тодорхой санал бэлтгэн хүргүүлэх саналтай байна.

Д.Цэрэнжав: Мөнхбат гишүүн уул уурхайн салбарын мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах санал гаргаж байна. Миний бодлоор бол манайд уул уурхайн мэдээлэл дутаагүй, харин төрийн байгууллага, компаниудын өгч байгаа мэдээлэл орон нутгийн иргэдэд хэрэгтэй байж чадахгүй байна. Нэгдсэн, бүхэл, статистик мэдээлэл зонхилж байна. Манай ОУИТБС-ын тайлан жилд нэг удаа гаргдаг учраас энэ утгаараа академик түвшний том том тоон мэдээлэл болчихоод байна. Үүнээс болоод төрийн байгууллага, манай санаачилга иргэдийн хооронд мэдээллийн үл ойлголцол, зөрүү гараад байна. Тиймээс өнөө маргаашийн сургалт семинар хөөцөлдөхөөс илүүтэйгээр уул уурхайн, ОУИТБС-ын мэдээллийг орон нутгийн иргэдэд яаж хэрэгтэй болгох талаар дараагийн алхмыг харж ажиллая.

Төр засгийн байгууллагууд, ОУИТБС-ын санаачилга болон ИНБ-уудын гаргаж байгаа мэдээллийг нэгтгэсэн томоохон платформыг бий болгох шаардлагатай. Тухайлбал, Нээлттэй нийгэм форумын хийсэн гэрээний сайтад маш их хэмжээний мэдээлэл оруулж, томоохон ажлууд хийгдэж байгаа, мөн манай байгууллага ашиг хүртэгч компаниудын мэдээллийг харуулсан том сайт хийсэн байгаа гэх мэтээр байгууллагууд өөр өөрийн чиглэлээр маш их мэдээлэл бэлтгэж байгаа. Энэ бүгд маань тарчихсан байгаа учраас орон нутгийн иргэдэд чиглэгдээгүй, мэдээлэл суртчилгаа дутагдалтай юм шиг харагдаж байна. ОУИТБС-ын тайлан гарахыг бүтэн жил хүлээх шаардлагагүй, харин мэдээллийг жилийн турш байнга шинэчилж байдаг болмоор байна. Тийм боломж бий.

Энэ бүх асуудлаар арга зүйн хэлэлцүүлэг зохион байгуулах саналтай байна.

Б.Баяраа: Би Цэрэнжав гуайн саналыг дэмжиж байна. Тухайн аймаг орон нутагт нь холбоотой мэдээллийг өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна. Бид хоорондоо холбоотой байж, уул уурхайн салбарын мэдээллийн гүүр болж өгмөөр байна.

Д.Эрдэнэчимэг: Төрийн өмчит компаниудад зориулсан сургалт хийхээс өмнө ажлын хэсгийн гишүүдтэй холбоотой байгаарай. Энэ шилэн дансны хуулийн дагуу 5 сая төгрөгөөс дээш гүйлгээний талаарх мэдээллийг ил болгох заалт байдаг, энэ ажлыг тэр бүр шахаж чадахгүй байгаа. Хэрвээ сургалт зохион байгуулвал бид тодорхой нэг бүлэг агуулгыг боловсруулан оролцох саналтай байна.

Мөн Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнгээс ТӨК-уудад зориулан удирдамж гаргасан байгаа. Эрдэнэс монгол ХК-тай бас засаглалын асуудлаар хамтран ажиллаж байгаа байх.

Иймд энэ байгууллагыг бас сургалтандаа татан оролцуулж, цогц сургалт хийгээсэй гэсэн албан ёсны санал байна.

Гэрээний сайтад 797 гэрээг 2019 оны 6 сарын байдлаар татаж оруулсан. Үүнд хөрөнгө оруулалт,

бүтээн байгуулалтын том гэрээнүүдээс гадна орон нутгийн бүх гэрээнүүдийг татаж оруулсан байгаа. Энэ жилийн хувьд оруулахаар бэлдэж байгаа 200 гаруй ашиглалтын өмнөх гэрээ байгаа, үүнийг Ашигт малтмалын газар хийдэг байна. Орон нутагт хийгдэж байгаа гэрээг тухайн орон нутгийн ЗДТГ-ын уул уурхай хариуцсан мэргэжилтэн жил жилдээ оруулахаар Засаг даргын УУХҮЯ-тай байгуулсан гэрээнд тусгасан байгаа гэхдээ сайтыг харахаар энэ жил орон нутгаас гэрээ оруулах асуудал зогсонги байдалтай байна. Бид өөрсдийн шугамаар гэрээгээ оруулахыг шахна гэхдээ УУХҮЯ болон Ажлын албаны зүгээр гэрээгээ оруулахыг шаардан дэмжээд өгвөл сайн байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалаа батлуулаад, иргэдээс санал авах ажил байгаа. УУХҮЯ-наас санаачилгатай ажиллаж чадаагүй, ажлын хэсгийн гишүүд болон ИНБ-ууд хуулийн төслийг боловсруулахад санаачилга гарган идэвхтэй ажилласан. Одоо хуулийн төслийг яамны сайтад байршуулаад олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулахыг УУХҮЯ болон Дамба даргаас хүсч байна, бид ч өөрсдийн шугамаар санал авах ажлыг яаралтай зохион байгуулах ажилд оролцох болно.

Үндсэн хуулийн 6,2 заалттай холбоотой УУХҮЯ-нд ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсэг өнгөрсөн жилийн 2 сараас хойш зогсонги байдалтай байна. Энэ заалт нь манай ОҮИТБС-тай холбоотой гэж би харж байна. Энэ заалтад нийтийн өмч байна, үүний хүрээнд мэдээлэл авах эрхтэй гээд мэдээллийн ил тод байдлын тухай бидний ажиллаад байгаа зүйлийг Үндсэн хуульд оруулаад заасан байгаа учраас үүний дагуу бусад салбарын хуулиудад ил тод байдлын тухай заалтууд, байгаль орчны нөлөөлөл гэх мэт заалтууд яаж тусгах талаар бид нилээд оролцоотой ажиллах ёстой гэж бодож байна. Одоогоор энэ ажлын хэсэгт ИНБ-ын төлөөлж ННФ орсон байгаа цаашлаад ажлын албанаас хүн орох ч юмуу энэ ажлыг урагшлуулах тал дээр яам маань ажилламаар санагдаж байна. Энэ ажлын хэсгийн явц ямар байгаа, УИХ-дээ байгуулагдсан Төрийн нийтийн өмчийн төсөл боловсруулах ажлын хэсэгтэй бид яаж хамтарч ажиллах вэ? Энэ талаар мэдээлэл авмаар байна, санал нь ажлын хэсгийн ажлыг шуурхайлж өгнө үү гэсэн саналтай байна.

Д.Дамба: За баярлалаа, бид өнгөрсөн хавар хуулийн төслийн үзэл баримтлал батлуулахад Эрдэнэчимэг гишүүн идэвхтэй ажилласан. Эрдэс баялагийн салбарт байгуулсан 700 гаруй гэрээг ил тод болгосон одоо нэмээд 200 гаруй гэрээг ил болгохоор ажиллаж байна. Өнгөрсөн 5 дахь өдөр Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг. Үүнд бид салбарын гол хуулиудыг шигтгэж оруулж өгсөн. Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль маань орж байгаа. Энэ хүрээнд УУХҮЯ-ны үйл ажиллагааны төлөвлөгөөг төсвийн тодотгол, Засгийн газрын бүтэцтэй уялдуулан шинэчлэх ажлыг зохион байгуулах Сайдын өгсөн чиглэлийн дагуу эхлүүлж байна. Эдгээр ажил нь 2020-2025 оны Монгол улсыг хөгжүүлэх ажлын үндсэн чиглэлтэй мөн уялдан хийгдэж байна. Эрдэнэчимэг гишүүний саналыг дагуу Эрдэс баялагийн ил тод байдлын хуулийн ажлыг идэвхжүүлнэ. ОҮИТБС-ын Үндэсий зөвлөлийн даргаар УУХҮ-ийн Сайд, нарийн бичгийн даргаар УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал ажиллаж байгаа цаашдаа бид хамтран ажиллах болно, үйл ажиллагаа улам өргөжинө, олсон амжилтаа бататгана гэж харж байна. Удахгүй орон нутгийн сонгууль болно, сонгуулийн дараа тухайн орон нутгийн шинэ удирдлагуудтай хамтран уулзалт хийх, ялангуяа тухай орон нутагт чиглэсэн манай санаачилга, яам агентлагийн хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлыг таниулах цаашдаа үйл ажиллагааг хэрхэн бэхжүүлэх талаар хийгдэх ажлууд эрчимжих байх. Ковид -19 цар тахалтай холбоотойгоор зарим ажлууд хийхээр

төлөвлөсөн зарим ажлууд хийгдээгүй байгаа. Өнөөдрийн хурлын үйл ажиллагааны талаар сайд болон төрийн нарийн бичгийн даргад танилцуулна. Та бүхний гаргасан тодорхой саналуудыг нэгтгэж томъёолон хурлын үр дүнг танилцуулна.

Бид уул уурхайн салбарын талаарх мэдээлэл, санаачилгын хүрээнд хийж буй ажлуудыг суртчилан таниулах ажлын хүрээнд цаашдаа хамтран ажиллах шаардлага байгаа гэж харж байна. Энэ жилийн ажлын төлөвлөгөөний томоохон ажил болох ОУИТБС-ын нэгтгэл тайлан гаргах ажлыг хуулийн дагуу цаг хугацаанд нь хийгээд явсан боловч үнэлгээний явцад гомдол гарч улмаар тендер хүчингүй болсон байна. Өмнөх үнэлгээний хороог татан буулгаж, шинээр байгуулан өнгөрсөн Баасан гаригт тендерийн зарыг дахин зарласан байгаа. Энэ ажил маань нилээд шахуу хийгдэхээр байгаа хуулийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөж байна. Нэгтгэл тайлан гаргах үйл явцад та бүхнийг ч идэвхтэй хамтран ажиллахыг хүсч байна.

Ажлын хэсгийн хурлын хоёрдугаар асуудал болох ОУИТБС-ын Харилцаа, сургалтын модулийн танилцуулгыг тус ажлын албаны харилцааны зөвлөх танилцуулах байсан боловч эрүүл мэндийн шалтгааны улмаас өнөөдөр танилцуулагдах боломжгүй гэж албан ёсоор мэдэгдсэн тул хойшлогдож байна. Бид ойрын хугацаанд яамны шинэ сайд болон удирдлагуудад ОУИТБС-ын талаарх мэдээлэл танилцуулга хийж, уулзахаар төлөвлөж байна. Ингээд өнөөдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье, баярлалаа.  
Хуралдаан 12.50 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:


УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга:



Г.Нандинжаргал

Хуралдааныг даргалсан:

УУХҮЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын эдийн засаг, хөрөнгө оруулалт, судалгааны хэлтсийн дарга



Д.Дамба

Тэмдэглэлийн хянасан:

ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОУИТБС-ын Ажлын албаны Санхүүгийн ажилтан



А.Отгонтунгалаг